



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/389

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3, 7.1.5, 7.1.6 Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4 дэх заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэстний байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас Япон улсын Засгийн газартай хамтран зохион байгуулагдах “Гамшгийн эрсдэлийг бууруулах Ази, Номхон далайн сайд нарын хурал”-д Дундговь аймгийн Онцгой байдлын газрын нэг албан хаагчийг оролцуулахад 2,000,000 (хоёр сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111281